

## ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**Эрүүл мэнд:** Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

**Биеийн тамир, спорт:** Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжин, тамирчдын тив, дэлхий, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

**Боловсрол:** Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон, насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.

**Шинжлэх ухаан, технологи, инноваци:** Судалгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулж, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр ашгийг нэмэгдүүлсэн байна.

**Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжил:** Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэж, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжин амьдралын чанарыг дээшлүүлнэ.

**Үндэсний бахархал, өв соёл:** Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэн, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

### ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

**Эдийн засаг:** Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрт хүрсэн, дундаж давхарга зонхилсон, эдийн засгийн суурийг бүрдүүлж, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бэхжүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай аймаг болно.

**Уул уурхай, хүнд үйлдвэр:** Байгальд ээлтэй технологи бүхий ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр:** Бэлчээрийн даацад нийцсэн ашиг шим өндөртэй эрүүл малыг өсгөн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлнэ.

**Аялал жуулчлал:** Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

**Эрчим хүч:** Эрчим хүчний найдвартай, аюулгүй тогтвортой байдлыг хангана.

**Тээвэр, логистик:** Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөжүүлнэ.

**Барилга, хот байгуулалт, хүнд ээлтэй амьдрах орчин:** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлагыг хэрэгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

## ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

**“Цахим Монгол” төрийн шуурхай үйлчилгээ:** Төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

**Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба:** Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгаж, төрийн чиг үүргийн уялдааг ханган, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгоно.

**Амар тайван, аюулгүй нийгэм:** Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.

**Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого:** Гадаад бодлого, харилцаа хамтын ажиллагааг тогтвортой хэрэгжүүлнэ.

**Батлан хамгаалах:** Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэнэ.

## НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**Тусгай хамгаалалттай газар нутаг:** Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.

**Байгалийн нөөц:** Байгалийн нөөцийг хамгаалж, нөхөн сэргээж, зохистой ашиглалтыг бий болгоно.

**Хүрээлэн буй орчин:** Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулна.

**Уур амьсгалын өөрчлөлт:** Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлнэ.

## БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

**Орон нутгийн хөгжил:** Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан, бүс, орон нутаг, төв суурин газрын төлөвлөлтийг оновчтой хийнэ.



**.Аймгийн Засаг даргын Тамгын газрын орчны шинжилгээ**

<b>Давуу тал</b>	<b>Сул тал</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэшсэн, чадварлаг хамт олон бүрдсэн</li> <li>- Төрийн албан хаагчдын ажиллах орчин бүрдсэн.</li> <li>- Иргэд, олон нийтэд мэдээлэл хийх танхим хүрэлцээтэй</li> <li>- Мэдээллийн ил тод байдал бий болсон</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэл хотоос алслагдсан</li> <li>- Ажлын ачаалал их, илүү цагаар ажилласан тохиолдолд илүү цагийн хөлс олгодоггүй.</li> <li>- Төрийн албан хаагчдын гадаад, дотоодод туршлага судлах боломж дутмаг</li> <li>- Авто машины парк шинэчлэл сүүлийн 10 жилд хийгдээгүй</li> <li>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд нь Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагийн мэргэжилтнүүдтэй ангилал зэрэглэл адил түвшинд байдаг</li> </ul>
<b>Боломж</b>	<b>Бэрхшээл</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Шийдвэр гаргах түвшинд асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэдэг.</li> <li>- Бодлого боловсруулах түвшинд мэргэшсэн хамт олон багаар ажиллаж, орон нутгийн хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах</li> <li>- Хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхдээ бүсийн тулгуур төвийн түвшинд авч үзэх боломжтой</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төсөв хязгаарлагдмал</li> <li>- Удирдлагын босоо тогтолцоотой хэлтэс, агентлагийн үйл ажиллагааг нэгдмэл удирдлагаар хангахад бэрхшээлтэй</li> <li>- Дэвшилтэд техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд санхүүгийн нөөц хүрэлцээгүй</li> <li>-</li> </ul>